



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/161

Мөрөн сум

“Оюутан цэрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалах яамны 2023 оны 1в/1170 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах хүсэлт гаргасан оюутан, сурагчдын сонгон шалгаруулалтыг батлан хамгаалах яамнаас тогтоосон хяналтын тоонд багтаан 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулж явуулсугай.

2. “Оюутан цэрэг” сургалтыг зохион байгуулах бэлтгэлийг хангаж, Хөвсгөл аймаг дахь Политехник коллежтэй хамтран хүсэлт гаргасан оюутан, сурагчдыг бүртгэх, сонгон шалгаруулалт явуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, цэргийн ерөнхий болон мэргэжлийн бэлтгэл шатны хөтөлбөр, төлөвлөгөөнд заагдсан хичээл, сургалтыг чанартай зохион байгуулахыг Цэргийн штабын дарга (хурандаа С.Батхуяг)-д хариуцуулсугай.

3. “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах хүсэлт гаргасан оюутан, сурагчдад эрүүл мэндийн үзлэг явуулах нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарыг томилгоожуулан Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын дагуу холбогдох зааварчилгаа өгч мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (Д.Түвшинбаяр)-т үүрэг болгосугай.

4. “Оюутан цэрэг” хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад тэнцсэн сурагчдын холбогдох бичгийн баримт бүрдүүлэн сургалтын явцад хичээлийн байр, танхимаар хангах, сурагчдын сахилга бат, зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн захирал (Н.Баатар-Очир)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6710010602